ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/62/СТА-ТШ3


Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг. ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn.
Аудитор: Г.Энхтөр
Утас: 99032916 Цахим хаяг: ij17.audit@gmail.com



Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг, Сайншанд сум)
2020 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ ........ 3
2 Аудитын тайлан........ 5
2.1. Оршил........ 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт........ 6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 8
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 8
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга........ 9
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 9
2.12. Шилэн дансны мэдээлэл ........ 10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........ 10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл........ 10
3 Менежментийн захидал ........ 11
4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ........ 13

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 № 1-6/270

танай_____________-ны №_____________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН 9 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Д.ШИНЭЖАРГАЛ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Д.Шинэжаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 30-наас 2020 оны 2 дугаар сарын 3–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар Ингүүмэл жаргалант аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэг нь Удирдлагын оновчтой менежментийг дэмжин, багаар ажиллах, хамт олныг манлайлах ур чадвар, төрийн алба, багшийн ёс зүйг чандлан сахин "Чадварлаг баг" бүрдүүлэн СӨБ-ын үйлчилгээний шинэ арга хэлбэрийг дэмжих замаар хүүхэд бүрийг сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулж бага насны хүүхдийг хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулах, хүүхдийн нас, зан төлөвийг таньж мэдэн хүүхдээ ойлгож дэмжин туслах замаар боловсрол эзэмших, авьяас чадвараа хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах  шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад  бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 33 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа тул материаллаг байдлын сууриар нийт зардлыг сонгосонтой холбоотой юм.

2019 оны нийт зардал 454,876.68 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 909.75 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,998.50 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 834.00 | - | (834.00) |
| Авлага | 2,496.70 | | (2,496.70) |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 37,743.10 | 59,408.50 | 21,665.40 |
| Үндсэн хөрөнгө | 1,035,184.50 | 1,043,848.30 | 8,663.80 |
| **Нийт хөрөнгө** | **1,076,258.30** | **1,103,256.80** | **26,998.50** |
| Өр төлбөр | | 849.20 | 849.20 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,076,258.30 | 1,102,407.60 | 26,149.30 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,076,258.30** | **1,103,256.80** | **26,998.50** |

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 2019 оны эцэст 10,600.0 мянган төгрөгийн зөөлөн эдлэл бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Улсын төсвийн хөрөнгөөр цэцэрлэгийн барилгын дээврийг засварласан, мөн аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгө бэлтгэснээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 19,594.3 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 32,858.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 822.8 мянган төгрөг, ИТХ-ын шийдвэрээр акталсан 435.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 1,834.02 мянган төгрөгийн бичилт нь 2018 онд нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 1,000.00 мянган төгрөгийг эргүүлэн олгохгүй болсон тул тус авлагыг хаасан, 834.02 мянган төгрөгийг ахмадын сангийн программ үүсгүүлэн үндсэн данснаас салган шилжүүлсэнтэй холбоотой байна.

### 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 449,468.60 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт зардлын 402,237.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 47,331.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 449,059.72 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь байр ашиглахтай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

**Нэмэлт төсөв:** Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого болон нэмэлт санхүүжилт байхгүй.

### 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар мөнгөн дүнгээр илэрхийлэгдээгүй 2 асуудлыг алдаа зөрчилд тооцон алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй.

**2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэг нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

**2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт тогтоосон бөгөөд актын биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

**2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

**“Зөрчилгүй” дүгнэлт**

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан заавар, маягтын дагуу хөтөлдөггүй байна
2. Цалин олгох хүснэгт /НХМаягт ЦХ 5б маягт/-г холбогдох банкны ажилтнаар хүлээн авсан тухай баталгаажуулаагүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын газарт 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

3.1 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.1.1 Илрүүлэлт:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан заавар, маягтын дагуу хөтөлдөггүй байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх, ээлжийн амралтын тооцоог зөрүүтэй тооцох.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу цэцэрлэгийн эрхлэгч хөтлөх бөгөөд нягтлан бодогч уг мэдэгдлийг үндэслэн ээлжийн амралтын тооцоо, олговрыг бодож холбогдох санхүүгийн баримтын хамт хадгалах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хэрэгжүүлж ажиллана.

3.2 Дотоод аудит

3.2.1 Илрүүлэлт:

Цалин олгох хүснэгт /НХМаягт ЦХ 5б маягт/-г холбогдох банкны ажилтнаар хүлээн авсан тухай баталгаажуулаагүй байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байх, цалингийн зөрүү үүсэх, цалин эзэндээ олгогдоогүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Ажилчдын цалинг арилжааны банкаар дамжуулан олгохдоо цалин олгох хүснэгт /НХМаягт ЦХ 5б маягт/-г банкны ажилтан хүлээн авсан тухай гарын үсэг зуруулж баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хэрэгжүүлж ажиллана.

# 4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

## 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

## 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

## Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

### 4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

| | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **41,073,811.17** | **59,408,529.78** |
| 2 | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **834,016.39** | **-** |
| 8 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **834,016.39** | **-** |
| 9 | **Төгрөг** | **834,016.39** | **-** |
| 14 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 834,016.39 | - |
| 27 | **АВЛАГА** | **2,496,720.00** | **-** |
| 30 | Татаас санхүүжилтийн авлага | 1,000,000.00 | - |
| 34 | **Бусад авлага** | **1,496,720.00** | **-** |
| 35 | Байгууллагаас авах авлага | 1,347,658.00 | - |
| 36 | Хувь хүмүүсээс авах авлага | 149,062.00 | - |
| 60 | **БАРАА МАТЕРИАЛ** | **37,743,074.78** | **59,408,529.78** |
| 61 | **Түүхий эд материал** | **5,414,325.68** | **5,434,525.68** |
| 62 | Тусгай зориулалттай материал | 5,344,525.68 | 5,344,525.68 |
| 63 | Эм боох материал | 69,800.00 | 90,000.00 |
| 66 | **Хангамжийн материал** | **32,328,749.10** | **53,974,004.10** |
| 67 | Бичиг хэргийн материал | 243,900.00 | 533,500.00 |
| 68 | Аж ахуйн материал | 28,017,798.10 | 45,383,988.10 |
| 70 | Түлш шатах тослох материал | 60,000.00 | - |
| 72 | Хүнсний материал | 736,000.00 | 4,785,465.00 |
| 73 | Бусад хангамжийн материал | 3,271,051.00 | 3,271,051.00 |
| 86 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,035,184,500.62** | **1,043,848,333.92** |
| 106 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,035,184,500.62** | **1,043,848,333.92** |
| 108 | **Биет хөрөнгө** | **998,720,500.62** | **1,007,384,333.92** |
| 109 | Барилга, байгууламж | 964,646,646.00 | 996,422,923.00 |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл | - | (34,421,699.88) |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 62,291,344.99 | 69,877,554.99 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (44,449,375.05) | (48,715,391.66) |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,682,060.72 | 46,242,657.67 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (22,584,071.36) | (26,122,179.60) |
| 122 | Бусад үндсэн хөрөнгө | 2,416,301.00 | 2,416,301.00 |
| 123 | Хуримтлагдсан элэгдэл | - | (305,725.92) |
| 125 | Номын фонд | 1,717,594.32 | 1,989,894.32 |
| 126 | **Биет бус хөрөнгө** | **36,464,000.00** | **36,464,000.00** |
| 127 | Програм хангамж | 825,000.00 | 825,000.00 |
| 128 | Хасагдуулга | (825,000.00) | (825,000.00) |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | 36,464,000.00 | 36,464,000.00 |
| 137 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,076,258,311.79** | **1,103,256,863.70** |
| 138 | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **-** | **849,271.00** |
| 139 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **849,271.00** |
| 164 | **Өглөг** | **-** | **849,271.00** |
| 165 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | - | 849,271.00 |
| 214 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **1,076,258,311.79** | **1,102,407,592.70** |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 1,076,258,311.79 | 1,102,407,592.70 |
| 216 | **Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан** | **810,393,938.28** | **810,393,938.28** |
| 217 | Өмч: -Төрийн өмч | 810,393,938.28 | 810,393,938.28 |
| 223 | **Хуримтлагдсан үр дүн** | **(90,271,436.05)** | **(64,122,155.14)** |
| 224 | Өмнөх үеийн үр дүн | (90,271,436.05) | (92,105,452.44) |
| 225 | Тайлант үеийн үр дүн | - | 27,983,297.30 |
| 227 | **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | **356,135,809.56** | **356,135,809.56** |
| 231 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **1,076,258,311.79** | **1,103,256,863.70** |

## 4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

| Үзүүлэлт | | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **334,193,317.13** | **482,859,973.95** |
| 76 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,014,000.74** | **33,291,373.95** |
| 77 | **Нийтлэг татварын бус орлого** | **9,014,000.74** | **33,291,373.95** |
| 81 | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **9,014,000.74** | **33,291,373.95** |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,014,000.74 | 33,291,373.95 |
| 111 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **47,331,600.00** |
| 119 | **Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих** | **323,066,300.00** | **402,237,000.00** |
| | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,113,016.39** | |
| | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | 1,000,000.00 | |
| | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,113,016.39 | |
| 129 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **-** | **47,331,600.00** |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 47,331,600.00 |
| 147 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **344,863,046.61** | **454,876,676.65** |
| 148 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **344,863,046.61** | **454,876,676.65** |
| 149 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **344,175,901.72** | **454,367,799.65** |
| 150 | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **196,837,053.59** | **264,612,633.00** |
| 151 | Цалин | 177,996,759.59 | 257,558,156.00 |
| 152 | Нэмэгдэл цалин | 5,240,400.00 | |
| 154 | Урамшуулал | 13,599,894.00 | 7,054,477.00 |
| 157 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **24,097,326.98** | **34,025,809.00** |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 16,184,923.53 | 23,564,284.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,996,603.09 | 2,643,236.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,610,803.44 | 2,170,905.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 396,163.32 | 526,199.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 3,908,833.60 | 5,121,185.00 |
| 164 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **35,078,224.00** | **42,213,799.00** |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 2,484,852.00 | 2,836,275.00 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 26,301,660.00 | 31,515,792.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 6,291,712.00 | 7,861,732.00 |
| 170 | **Хангамж, бараа материалын зардал** | **2,229,773.00** | **2,795,212.00** |
| 171 | Бичиг хэргийн материал | 127,199.00 | 642,000.00 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 60,000.00 | 220,000.00 |
| 173 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 79,895.00 | 67,157.00 |
| 174 | Ном, хэвлэлийн зардал | - | 26,700.00 |
| 175 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | - | 150,000.00 |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 998,880.00 | 1,124,915.00 |
| 178 | Бараа материал акталсны зардал | 963,799.00 | 564,440.00 |
| 181 | **Нормативт зардал** | **59,249,950.00** | **64,105,245.00** |
| 182 | Эм | 29,000.00 | 167,670.00 |
| 183 | Хоол | 59,214,950.00 | 63,730,575.00 |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,000.00 | 207,000.00 |
| 185 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **438,225.00** | **786,620.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 189 | Урсгал засвар | 438,225.00 | 786,620.00 |
| 190 | **Томилолт, зочны зардал** | **90,000.00** | **465,100.00** |
| 192 | Дотоод томилолтын зардал | 90,000.00 | 465,100.00 |
| 194 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | **996,861.11** | **1,023,141.00** |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 996,861.11 | 963,141.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | - | 60,000.00 |
| 209 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **25,158,488.04** | **44,340,240.65** |
| 211 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,077,900.00 | 550,900.00 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,080,588.04 | 43,789,340.65 |
| 224 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **687,144.89** | **508,877.00** |
| 228 | **Бусад урсгал шилжүүлэг** | **500,000.00** | **100,000.00** |
| 236 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 500,000.00 | 100,000.00 |
| 237 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **187,144.89** | **111,076.00** |
| 240 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 187,144.89 | 111,076.00 |
| 242 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **297,801.00** |
| 245 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 297,801.00 |
| 268 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **(10,669,729.48)** | **27,983,297.30** |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **1,260,829.03** | |
| | Үнэ төлбөргүй гарсан зардал | 1,260,829.03 | |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)** | **(1,260,829.03)** | |
| 288 | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **(11,930,558.51)** | **27,983,297.30** |

### 4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

| | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **325,179,316.39** | **449,568,600.00** |
| 110 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **325,179,316.39** | **449,568,600.00** |
| 118 | **Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих** | **323,066,300.00** | **402,237,000.00** |
| | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,113,016.39** | |
| | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | 1,000,000.00 | |
| | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,113,016.39 | |
| 129 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **-** | **47,331,600.00** |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 47,331,600.00 |
| 147 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **322,279,210.00** | **449,568,600.00** |
| 148 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **322,279,210.00** | **449,568,600.00** |
| 149 | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **320,592,065.11** | **449,059,723.00** |
| 150 | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **198,201,721.00** | **262,957,351.00** |
| 151 | Үндсэн цалин | 174,987,021.00 | 175,131,351.00 |
| 152 | Нэмэгдэл | 9,432,700.00 | 59,666,800.00 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 6,072,000.00 |
| 154 | Үр дүнгийн урамшуулал | 13,782,000.00 | 22,087,200.00 |
| 157 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **24,581,400.00** | **33,335,100.00** |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 17,088,965.00 | 24,813,828.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,102,790.00 | 1,181,376.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 373,672.00 | 1,349,401.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 92,461.00 | 1,433,688.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 4,923,512.00 | 4,556,807.00 |
| 164 | **Байр ашиглалтай  холбоотой тогтмол зардал** | **35,072,119.00** | **42,213,799.00** |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 2,478,747.00 | 2,836,275.00 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 26,301,660.00 | 31,515,792.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 6,291,712.00 | 7,861,732.00 |
| 170 | **Хангамж, бараа материалын зардал** | **1,831,924.00** | **5,934,465.00** |
| 171 | Бичиг хэрэг | 100,000.00 | 100,000.00 |
| 172 | Тээвэр, шатахуун | 60,000.00 | 160,000.00 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 86,000.00 | 73,400.00 |
| 174 | Ном, хэвлэл | 127,500.00 | 185,000.00 |
| 175 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 150,000.00 | 150,000.00 |
| 176 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,308,424.00 | 5,266,065.00 |
| 181 | **Нормативт зардал** | **57,344,940.00** | **77,626,910.00** |
| 182 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,800.00 | 97,870.00 |
| 183 | Хоол, хүнс | 56,871,140.00 | 67,780,040.00 |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 375,000.00 | 9,749,000.00 |
| 185 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,322,700.00** | **24,295,000.00** |
| 186 | Багаж техник хэрэгсэл | - | 9,570,000.00 |
| 187 | Тавилга | - | 9,905,000.00 |
| 189 | Урсгал засвар | 1,322,700.00 | 4,820,000.00 |
| 190 | **Томилолт, зочны зардал** | **90,000.00** | **390,200.00** |
| 192 | Дотоод албан томилолт | 90,000.00 | 390,200.00 |
| 194 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **846,861.11** | **1,006,898.00** |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 846,861.11 | 946,898.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 60,000.00 |
| 208 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,300,400.00** | **1,300,000.00** |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,300,400.00 | 1,300,000.00 |
| 221 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,687,144.89** | **508,877.00** |
| 225 | **Бусад урсгал шилжүүлэг** | **500,000.00** | **100,000.00** |
| 233 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 500,000.00 | 100,000.00 |
| 234 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,187,144.89** | **111,076.00** |
| 237 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,187,144.89 | 111,076.00 |
| 239 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **297,801.00** |
| 242 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 297,801.00 |
| 250 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **2,900,106.39** | **-** |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 261 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **2,066,090.00** | **-** |
| 262 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,066,090.00** | **-** |
| 263 | **Дотоод эх үүсвэрээр** | **2,066,090.00** | **-** |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,066,090.00 | - |
| 278 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(2,066,090.00)** | **-** |
| 279 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| 303 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **834,016.39** | **-** |
| 304 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **834,016.39** |

| | | | |
|---|---|---|---|
| 305 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **834,016.39** | **-** |

## 4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 2 | **2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | **773,929,938.28** | **356,135,809.56** | **(78,340,877.54)** | **1,051,724,870.30** |
| 3 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | **-** |
| 4 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **773,929,938.28** | **356,135,809.56** | **(78,340,877.54)** | **1,051,724,870.30** |
| 5 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | | | | **-** |
| 6 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | | | | **-** |
| 7 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | **-** |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 36,464,000.00 | | (11,930,558.51) | **24,533,441.49** |
| 9 | **2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **810,393,938.28** | **356,135,809.56** | **(90,271,436.05)** | **1,076,258,311.79** |
| 10 | **2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **810,393,938.28** | **356,135,809.56** | **(90,271,436.05)** | **1,076,258,311.79** |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | (1,834,016.39) | **(1,834,016.39)** |
| 12 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **810,393,938.28** | **356,135,809.56** | **(92,105,452.44)** | **1,074,424,295.40** |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | **-** |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | **-** |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | **-** |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | **-** |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | | 27,983,297.30 | **27,983,297.30** |
| 18 | **2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **810,393,938.28** | **356,135,809.56** | **(64,122,155.14)** | **1,102,407,592.70** |

### 4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

| Үзүүлэлт | | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** | **-** | **-** |
| 2 | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **449,568,600.00** | **449,568,600.00** | **-** | **100.00** |
| 3 | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **449,568,600.00** | **449,568,600.00** | **-** | **100.00** |
| 4 | **Бараа, үйлчилгээний зардал** | **449,468,600.00** | **449,059,723.00** | **408,877.00** | **99.91** |
| 5 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **263,060,300.00** | **262,957,351.00** | **102,949.00** | **99.96** |
| 6 | Үндсэн цалин | 175,234,300.00 | 175,131,351.00 | 102,949.00 | 99.94 |
| 7 | Нэмэгдэл | 59,666,800.00 | 59,666,800.00 | - | 100.00 |
| 8 | Унаа, болон бусад нөхөн олговор | 6,072,000.00 | 6,072,000.00 | - | 100.00 |
| 9 | Урамшуулал | 22,087,200.00 | 22,087,200.00 | - | 100.00 |
| 10 | Гэрээт ажлын хөлс | - | - | - | - |
| 11 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **33,335,100.00** | **33,335,100.00** | **-** | **100.00** |
| 12 | Тэтгэврийн даатгал | 23,149,600.00 | 24,813,828.00 | (1,664,228.00) | 107.19 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 2,037,100.00 | 1,181,376.00 | 855,724.00 | 57.99 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 2,546,300.00 | 1,349,401.00 | 1,196,899.00 | 52.99 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 509,300.00 | 1,433,688.00 | (924,388.00) | 281.50 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 5,092,800.00 | 4,556,807.00 | 535,993.00 | 89.48 |
| 17 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **42,506,600.00** | **42,213,799.00** | **292,801.00** | **99.31** |
| 18 | Гэрэл цахилгаан | 2,597,100.00 | 2,836,275.00 | (239,175.00) | 109.21 |
| 19 | Түлш, халаалт | 31,515,800.00 | 31,515,792.00 | 8.00 | 100.00 |
| 20 | Цэвэр, бохир ус | 8,393,700.00 | 7,861,732.00 | 531,968.00 | 93.66 |
| 22 | **Хангамж, бараа материалын зардал** | **5,938,800.00** | **5,934,465.00** | **4,335.00** | **99.93** |
| 23 | Бичиг хэрэг | 100,000.00 | 100,000.00 | - | 100.00 |
| 24 | Тээвэр (шатахуун) | 160,000.00 | 160,000.00 | - | 100.00 |
| 25 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 73,400.00 | 73,400.00 | - | 100.00 |
| 26 | Ном, хэвлэл | 185,400.00 | 185,000.00 | 400.00 | 99.78 |
| 27 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 150,000.00 | 150,000.00 | - | 100.00 |
| 28 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 5,270,000.00 | 5,266,065.00 | 3,935.00 | 99.93 |
| 30 | **Нормативт зардал** | **77,629,600.00** | **77,626,910.00** | **2,690.00** | **100.00** |
| 31 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,800.00 | 97,870.00 | 930.00 | 99.06 |
| 32 | Хоол, хүнс | 67,780,800.00 | 67,780,040.00 | 760.00 | 100.00 |
| 33 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 9,750,000.00 | 9,749,000.00 | 1,000.00 | 99.99 |
| 34 | **Эд хогшил худалдан авах** | **24,300,000.00** | **24,295,000.00** | **5,000.00** | **99.98** |
| 35 | Багаж, техник, хэрэгсэл | 9,570,000.00 | 9,570,000.00 | - | 100.00 |
| 36 | Тавилга | 9,905,000.00 | 9,905,000.00 | - | 100.00 |
| 38 | Урсгал засвар | 4,825,000.00 | 4,820,000.00 | 5,000.00 | 99.90 |
| 39 | **Томилолт, зочны зардал** | **390,200.00** | **390,200.00** | **-** | **100.00** |
| 41 | Дотоод албан томилолт | 390,200.00 | 390,200.00 | - | 100.00 |
| 43 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **1,008,000.00** | **1,006,898.00** | **1,102.00** | **99.89** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 948,000.00 | 946,898.00 | 1,102.00 | 99.88 |
| 45 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 60,000.00 | 60,000.00 | - | 100.00 |
| 53 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,300,000.00** | **1,300,000.00** | **-** | **100.00** |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,300,000.00 | 1,300,000.00 | - | 100.00 |
| 66 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **100,000.00** | **508,877.00** | **(408,877.00)** | **508.88** |
| 70 | **Бусад урсгал шилжүүлэг** | **100,000.00** | **100,000.00** | **-** | **100.00** |
| 76 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - | - | - |
| 77 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | - | - | - | - |
| 78 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 100,000.00 | 100,000.00 | - | 100.00 |
| 79 | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **408,877.00** | **(408,877.00)** | **-** |
| 80 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 111,076.00 | (111,076.00) | - |
| 81 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 297,801.00 | (297,801.00) | - |
| 97 | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **449,568,600.00** | **449,568,600.00** | **-** | **100.00** |
| 98 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **402,237,000.00** | **402,237,000.00** | **-** | **100.00** |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | - | - | - | - |
| 101 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 402,237,000.00 | 402,237,000.00 | - | 100.00 |
| 103 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **47,331,600.00** | **47,331,600.00** | **-** | **100.00** |
| 104 | Орон нутгийн төсвөөс | 47,331,600.00 | 47,331,600.00 | - | 100.00 |
| 120 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | - | - | - |
| 125 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | - | - | - |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - | 100.00 |
| 131 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.00 |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 25 | 25 | - | 100.00 |
| 134 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 14 | 14 | - | 100.00 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 10 | 10 | - | 100.00 |
| 138 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - | - | - |
| 148 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - | - | - |
| 152 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 25 | 25 | - | 100.00 |
| 156 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/ | 15 | 15 | - | 100.00 |
| 161 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/ | 10 | 10 | - | 100.00 |